



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 02 сарын 17 өдөр

Дугаар A/76

Булган сум

**“Нэг аймаг-Нэг тусламж” үйл ажиллагааг
зохион байгуулах тухай**

Монгол Улсын засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Эрүүл мэндийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.10 дахь заалт, Улсын Их Хурлын 2020 оны “Алсын хараа 2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого батлах тухай” 52 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтын зорилт 2.2, Эрүүл мэндийн сайдын 2024 оны А/367 дугаар тушаал, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2024 оны “Аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны Булганы сэргэлт хөтөлбөрийг батлах тухай” IV/25 дугаар тогтоол, 2024 оны IV хуралдааны “Булган аймгийн 2025 оны төсөв батлах тухай” IV/26 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Төвлөрлийг сааруулах “Нэг аймаг-Нэг тусламж” арга хэмжээг 2025 оны 02 дугаар сарын 07-нд зохион байгуулсугай.

2.Арга хэмжээний удирдамжийг 1 дүгээр, зарцуулагдах хөрөнгийн төсвийг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

4.Арга хэмжээнд зарцуулагдах 7,742,000 (долоон сая долоон зуун дөчин хоёр мянга) төгрөгийг хөтөлбөр, төлөвлөгөөг хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг Аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Д.Наранбаяр)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

Д.ПҮРЭВ-ОЧИР

Аймгийн Засаг даргын 2025 оны
02 дугаар сарын 17-ний өдрийн ...4/28 дүгээр
захирамжийн 1 дүгээр хавсралт

ТӨВЛӨРЛИЙГ СААРУУЛАХ "НЭГ АЙМАГ-НЭГ ТУСЛАМЖ"
АРГА ХЭМЖЭЭНИЙ УДИРДАМЖ

Нэг. Үндэслэл:

Орон нутагт нэн шаардлагатай тусламж, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, төвлөрлийг сааруулах, хүлээгдлийг бууруулах зорилгоор төрөлжсөн мэргэшлийн эрүүл мэндийн байгууллагаас тухайн тусламж, үйлчилгээг орон нутагт нутагшуулах зорилго бүхий "Зүрхний хэм судлал"-ын, "Ангиографи"-ийн "Гэмтэл, согог судлал"-ын, "Хавдар судлал"-ын үндэсний багууд Эрүүл мэндийн сайдын 2024 оны 08 дугаар сарын 30-ны өдрийн А/367 дугаар тушаалын дагуу аймаг, орон нутагт ажиллаж эхлээд байна.

Төрөлжсөн мэргэшлийн эмнэлгээс үзүүлж буй хүлээгдэл ихтэй тусламж, үйлчилгээг орон нутагтаа нутагшуулан, хүртээмжийг нэмэгдүүлэх замаар тусламж үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлэх, гүйцэтгэлийн санхүүжилтээ сайжруулахад дэмжлэгт хяналт зайлшгүй шаардлагатай юм.

Хоёр. Зорилго:

Улсын хэмжээнд төрөлжсөн мэргэшлийн эмнэлгээс үзүүлж буй нэн шаардлагатай тусламж, үйлчилгээг аймгийн нэгдсэн эмнэлэгт нутагшуулж, орон нутагт тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, хүлээгдлийг бууруулах.

Гурав. Зорилт:

1.Төрөлжсөн мэргэшлийн эмч нарын "Үндэсний баг"-ийн үйл ажиллагаатай танилцах, тусламж үйлчилгээ үзүүлэх, эмч мэргэжилтнийг ажлын байранд сургахад тулгамдаж буй асуудлаа танилцуулан шийдвэрлүүлэх

2.Хүлээгдэл ихтэй төрөлжсөн мэргэшлийн зарим тусламж, үйлчилгээг аймгийн Нэгдсэн эмнэлэгт үзүүлдэг болох, цаашид тогтвортой үзүүлэх нөхцөлийг бүрдүүлэхэд тулгамдаж буй асуудлаа танилцуулах, шийдвэрлүүлэх

Дөрөв. Хугацаа:

2025 оны 02 дугаар сарын 08

Тав. Хамрах хүрээ:

Аймгийн удирдлага

Нэгдсэн эмнэлгийн удирдлага, эмч, эмнэлгийн мэргэжилтэн

Өрхийн эрүүл мэндийн төвийн удирдлага, эмч, эмнэлгийн мэргэжилтэн

Сумын эрүүл мэндийн төвийн удирдлага, эмч, эмнэлгийн мэргэжилтэн

Эрүүл мэндийн даатгалын хэлтсийн удирдлага, мэргэжилтнүүд

Иргэд

Аймгийн Засаг даргын 2025 оны
2 дугаар сарын 17-ны/ний өдрийн 4/76 дүгээр
захирамжийн 2 дугаар хавсралт

“НЭГ АЙМАГ-НЭГ ТУСЛАМЖ” АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨСӨВ

№	Ашиглагдах материал	Тоо ширхэг	Нэгж үнэ	Өртөг
1	2	3	4	5
1	Өглөөний цай	35	15,000	525,000
2	Өдрийн хоол	45	49,954	2,247,500
3	Оройн хоол /багцаар/	45	99,325	4,469,500
4	LED	1	500,000	500,000
НИЙТ				7,742,000